

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.9.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.11.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.12.	Шилэн дансны мэдээлэл	10
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.14.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
2	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
3.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
3.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.25 № 06/570
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул Зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Эрүүл мэндийг дэмжих сан нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сангийн төсвийн захирагч, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Мөн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Сангийн удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Долгоржав, Д.Болор-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийг дэмжих сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Санхүүгийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 4-1/314 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Эрүүл мэндийг дэмжих сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Тус сан хүн амыг эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөллийг хүргэж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл аж төрөх ёсыг сурталчилах, орчныг бүрдүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулахад зорилгоо чиглүүлэн ажиллах үүрэгтэй ба сангийн өдөр тутмын үйл ажиллагааг тус яамны нийгмийн эрүүл мэндийн газар хариуцан гүйцэтгэдэг байна.

Эрүүл мэндийг дэмжих сан нь Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.41, 21⁸ дүгээр зүйл, Засгийн газрын 2017 оны 82 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм, сангийн хөрөнгийг зарцуулах журам”-д зааснаар сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг хянаж тайлагнах үүрэгтэй.

Сангийн хөрөнгөөр доорх арга хэмжээг санхүүжүүлж хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- орчны эрүүл мэндийг хамгаалах;
- осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй амьдралын орчныг бүрдүүлэх;
- сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, архи, тамхи, мансууруулах бодисын хорт нөлөөллөөс сэргийлэх;

- эмийн зохистой хэрэглээ;
- эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх;
- нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй болгох чиглэлээр хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын үр дүнтэй санаачилга, төсөл, хөтөлбөрийг дэмжих, урамшуулах;
- нийгмийн эрүүл мэнд, анагаах ухаан, эрүүл мэндийн шинжлэх ухааны дэвшилтэт технологийг эзэмшүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг гадаадад сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааг дэмжих.

Эрүүл мэндийг дэмжих сангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Эрүүл мэндийг дэмжих сангийн удирдлага төсөв захирагчийн хувьд дараах хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус сангийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийг дэмжих сан нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн "Axplorer" програм хангамж ашигладаг байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Эрүүл мэндийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлын 1.0 хувиар сонгов.

Тус сангийн төсвийн санхүүжилтийн 80 хувь нь эрүүл мэндийн боловсролын сургалт сурталчилгааны зардал эзэлдэг тул нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгов.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны нийт зардал 5,122.5 сая төгрөг бөгөөд түүний 1.0 хувь болох 51.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

№	Шийдэл	Тоо	Дүн	/сая төгрөгөөр/
				Тайлбар
1	Албан шаардлага өгсөн	5	35.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.0	
Дүн		5	35.7	

2.9.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудалгүй бөгөөд бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал 1. Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

а/ Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр орон нутгийн 6 өрхийн эмнэлэг 22.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь өмнөх онд гаргасан алдаа зөрчил давтагдсан;

б/ эрүүл мэндийн боловсролын сургалт сурталчилгааны материалын зардлыг хэмнэх, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгоор 2017 онд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвлэлийн цех, мэдээллийн студи байгуулахад 180.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн. Гэтэл тайлант онд эрүүл мэндийн боловсролд хэрэглэгдсэн сургалт сурталчилгааны материалыг тус төвийн студи, хэвлэлийн цехээр гүйцэтгүүлэлгүй үргүй зардал зэргийг давтан гаргажээ.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдэлтэй нийцээгүй, Төсвийн тухай хуулийн 14.2.3, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸.2, 21⁸.1, 32 дугаар зүйлийн 32.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиудын холбогдох заалтыг хэрэгжүүлэн, санхүүгийн сахилга батыг чанд сахиж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Асуудал 2. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/448 дугаар тушаалаар 691.5 сая төгрөгийг данс хаагдах өдөр харьяа байгууллагуудад шилжүүлсэн бөгөөд зарцуулалт болон санхүүгийн анхан шатны баримт тайлант

хугацааны бус, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтсан байна.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5; 6 дугаар зүйлийн 6.4.1; 7 дугаар зүйлийн 7.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын холбогдох заалтыг хэвшүүлэн ажиллах, санхүүгийн сахилга батыг сайжруулах албан шаардлага хүргүүлэх.

Асуудал 3. Зардлын данстай холбоотой асуудал

Эрүүл мэндийг дэмжих сангаас 5.4 сая төгрөгийг Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, 1.2 сая төгрөгийг Удирдах ажилтныг чадавхжуулах сургалтыг зохион байгуулахад тус тус зориулалт бус зарцуулсан.

Энэ нь “Эрх ба үүрэг” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸.4, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг зөрчсөн байна.

Шийдэл: Сангийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу зарцуулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Асуудал 4. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

2018 онд гадаад арга хэмжээнд 89.6 сая төгрөгийг зарцуулснаас Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/234 дүгээр тушаалаар салбарын бус албан тушаалтныг явуулж, зориулалт бус зарцуулалт гаргасан байна.

Энэ нь “Эрх ба үүрэг”, “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлүүдтэй нийцээгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸.4, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдэл: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21⁸.4, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Асуудал 5. Зардлын данстай холбоотой асуудал

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс гадаад томилолтын зардлыг 6.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.

Энэ нь “Хэмжилт”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалыг зөрчсөн.

Шийдэл: Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг баримталж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

Асуудал 6. Санхүүгийн тайлангийн аудитын явцад хийсэн залруулга

Санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудалд илэрсэн алдаанд залруулга хийлээ. Үүнд:

2017 оны санхүүгийн тайлангийн урьдчилж төлсөн зардал дансны үлдэгдлээс гэрээт ажлын гүйцэтгэлийг үндэслэн 97.2 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрсөн, тайлант оны 0.2 сая төгрөгийн өглөгийг гэрээ дүгнэсэн актаар баталгаажуулан тайланд залруулга хийлгэлээ.

2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалт тэдгээрт тавигдах хяналтыг хамруулах нь зүйтэй гэж үзэж байна.

2018 оны тайлант хугацааны эцэст Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийн үлдэгдлийг Сангийн яаманд "хураалгах"-гүйн тулд оны эцэст сайдын шийдвэрээр Төрийн сангийн гүйлгээ хаагдах өдөр эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлсэн байна. Эрүүл мэндийн яамны харьяа байгууллагуудад шилжүүлсэн хөрөнгийн зарцуулалт, бүрдүүлсэн анхан шатны баримтууд тайлант хугацааны бус байгаа нь анхаарал татахуйц байлаа.

2.11. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Эрүүл мэндийг дэмжих сан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой 1 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 5,000.0 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 5,000.0 сая төгрөг буюу 100.0 хувь зарцуулсан байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрүүл мэндийг дэмжих сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус сан Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн дагуу 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээний хэсэгт санхүүжилт болон зарцуулалтын гүйлгээг бүрэн байршуулан ажилласан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг аудитын явцад дахин нягталж үзэхэд 86 хувьтай байгаа бөгөөд хэрэгжилт хангалтгүй зөвлөмжийн талаар 2.9.1.1-д тусгаж албан шаардлага өглөө.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийг дэмжих сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	146,800.0	24,300.0
33	АВЛАГА	1,000.0	00.0
33500	Татаас, санхүүжилтийн авлага	1,000.0	00.0
33510	Байгууллагаас авах авлага	1,000.0	00.0
34	УРЬДЧИЛГАА	145,800.0	24,300.0
34600	Урьдчилж гарсан зардал	145,800.0	24,300.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	00.0	00.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	00.0	00.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	146,800.0	24,300.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.0	00.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	146,800.0	24,300.0
51	Засгийн газрын ху1вь оролцоо	1	24,300.0
512	Хуримтлагдсан үр дүн	146,800.0	24,300.0
51210	Өмнөх үеийн үр дүн	00.0	146,800.0
51220	Тайлант үеийн үр дүн	146,800.0	-122,500.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	146,800.0	24,300.0

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,971,000.0	5,000,000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,000.0	00.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,000.0	00.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,000.0	00.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.0	00.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,970,000.0	5,000,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,970,000.0	5,000,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,970,000.0	5,000,000.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,824,200.0	5,122,500.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,824,200.0	5,121,500.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,821,776.3	5,121,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,821,776.3	5,121,500.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,821,776.3	5,121,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,423.7	1,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,423.7	1,000.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,423.7	1,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	146,800.0	-122,500.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.0	00.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	146,800.0	-122,500.0

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,970,000.00	5,001,000.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.0	1,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	00.0	1,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.0	1,000.0
1200043	Урд оны үлдэгдлээс санхүүжих	00.0	1,000.0
122	Тусламжийн орлого	00.0	00.0
122002	Хандив тусламж /гадаад/	00.0	00.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,970,000.00	5,000,000.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,970,000.0	5,000,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,970,000.0	5,000,000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,970,000.0	5,001,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,967,576.3	5,001,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,967,576.3	5,000,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,967,576.3	5,000,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,967,576.3	5,000,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,423.7	1,000.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,423.7	1,000.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,423.7	1,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.0	00.0
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.0

3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.0	00.0	00.0	00.0
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	00.0	00.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.0	00.0	00.0	00.0
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.0	00.0	00.0	00.0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.0	00.0	00.0	00.0
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.0	00.0	00.0	00.0
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	146,800.0	146,800.0
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.0	00.0	146,800.0	146,800.0
D01	2018 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.0	00.0	146,800.0	146,800.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	00.00	00.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.0	00.0	146,800.0	146,800.0
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.0	00.0	00.0	00.0
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.0	00.0	00.0	00.0
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.0	00.0	00.0	00.0
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.0	00.0	00.0	00.0
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	-122,500.0	-122,500.0
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.0	00.0	24,300.0	24,300.0

3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Гүйцэтгэлийн	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт, хэтрэлт	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,000,000.0	5,000,000.0	00.0	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.0	00.0	00.0	00.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.0	00.0	00.0	00.0

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2019/10/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:		Эрүүл мэндийг дэмжих сан		сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр 6 өрхийн эмнэлэг 22.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь өмнөх онд гаргасан алдаа зөрчил давтагдсан, эрүүл мэндийн боловсролын сургалт сурталчилгааны материалын зардлыг хэмнэх, сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зорилгоор 2017 онд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд хэвлэлийн цех, мэдээллийн студи байгуулахад 180.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн. Гэтэл тайлант онд эрүүл мэндийн боловсролд хэрэглэгдсэн сургалт сурталчилгааны материалыг тус төвийн хэвлэлийн цех, студиэр гүйцэтгүүлэлгүй үргүй зардлыг давтан гаргасан байна.	22.3	Албан шаардлага хүргүүлэх	НЭМГ-ын дарга Мэргэжилтэн	Т.Энхзаяа Ж.Дөлгөөн
2	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А/448 дугаар тушаалаар 691.5 сая төгрөгийг данс хаагдах өдөр харьяа байгууллагуудад шилжүүлсэн бөгөөд зарцуулалт болон санхүүгийн анхан шатны баримт тайлант хугацааны бус, Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтсан байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Э.Содномжамц /асан/ Х.Отгонзул
3	Эрүүл мэндийг дэмжих сангаас 5.4 сая төгрөгийг Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, 1.2 сая төгрөгийг Удирдах ажилтныг чадавхжуулах сургалтыг зохион байгуулахад тус тус зориулалт бус зарцуулсан.	6.6	Албан шаардлага хүргүүлэх	ТЗУГ-ын мэргэжилтэн ахлах мэргэжилтэн	О.Оюунчимэг Я.Болормаа
4	2018 онд гадаад арга хэмжээнд 89.6 сая төгрөгийг зарцуулснаас Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/234 дүгээр тушаалаар салбарын бус албан тушаалтныг явуулж, зориулалт бус зарцуулалт гаргасан байна.	-	Албан шаардлага хүргүүлэх	Төрийн нарийн бичгийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Э.Содномжамц /асан/ Х.Отгонзул
5	Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс гадаад томилолтын зардлыг 6.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.	6.8	Албан шаардлага хүргүүлэх	ТЗУГ-ын ГХХАХ-ийн мэргэжилтэн	С.Болормаа
	Дүн	35.7			

